



**“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 9

Орхон аймаг

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудиторын
2025 оны ажлын төлөвлөгөөг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7.17.7 дахь заалт, “ЭДЦС” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 31 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын үйл ажиллагааны журам”-ын 5.1.2 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн а/827 тоот удирдамжийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудиторын 2025 оны ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (О.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ЭРХЭМБАЯР

“ЭДЦС” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн
9 тогтоолын хавсралт



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
ДОТООД АУДИТОРЫН 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

Орхон аймаг

1. Дотоод аудит хийх үндэслэл:

Монгол Улсын Төрийн аудитын тухай, Төрийн хянан шалгалтын тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Эрчим хүчний тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.1, болон ТУЗ-ийн аудитын хорооны үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудиторын үйл ажиллагааны журмыг тус тус үндэслэн батлагдсан төлөвлөгөөт хуваарийн дагуу дотоод аудитыг явуулна.

2. Дотоод аудитын зорилго:

Компанийн санхүүгийн үйл ажиллагаа нь Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, заавар журам, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцэж байгаа эсэх, мөн гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан дүрэм, журмуудын хэрэгжилтэд дотоод аудит хийж үнэлэлт дүгнэлт гарган илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж өгөх.

3. Дотоод аудитын хамрах хүрээ:

Аудит, хяналт шалгалтыг Компанийн 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааг хамруулна.

4. Аудитын ажлын чиглэл:

№	Хамрагдах алба, хэлтэс, цех	Ажлын хамрах хүрээ	Хийх хугацаа	Гүйцэтгэх хоног
1	ЗУХ, СБЭЗХ, ХААХ, ИА	Шилэн дансны тухай хууль, журмын дагуу компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн сайтад бүрэн оруулсан эсэхэд аудит хийх.	Хагас жил тутам	30 хоног
2	СБЭЗХ, ДШС	Дулааны борлуулалтын орлогод 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар дотоод аудит хийх.	4 сард	22 хоног

3	ЗУХ, СБЭЗХ, ХААХ, ИА, ДХХ, Цахилгаан цех, ДХХА,	2024 онд ISO27001:2021 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх төслийн эрсдлийн багийн ажлыг дуусгах, МАБ-ын эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний дагуу дотоод аудит хийх.	5 сард	20 хоног
4	Холбогдох нэгжүүд	Сосо загвараар дотоод хяналтаа үнэлэх (ЭХЯ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу)	6 сард	20 хоног
5	ХААХ, СБЭЗХ	Компанийн 2025 оны хагас жилийн бараа материалын дансанд аудит хийх.	8,9 сард	30 хоног
6	ХААХ, Үнэлгээ хороо	Худалдан авах үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө гүйцэтгэлд, хяналт шалгалт хийж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх.	10,11 сард	40 хоног
7	ЗУХ, СБЭЗХ, ХААХ, ИА	2025 оны жилийн санхүү балансын тайланд аудит хийх.	2025 оны 12 сар, 2026 оны 1,2 сард	60 хоног
8	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх.			20 хоног

5. Сургалт ба хөгжүүлэлт, бусад

Дотоод аудитор нь ажлын ур чадвартай байх, мэргэжлээ тасралтгүйгээр хөгжүүлэх замаар мэдлэг ур чадвар, бусад чадвараа сайжруулах, хамгийн сүүлийн үеийн хөгжил дэвшлийг даган хөгжиж байх ёстой гэж заасан үндэслэн сургалт хөгжүүлэлтийн төлөвлөгөө гаргалаа.

№	Сургалт хөгжүүлэлт, бусад	Хугацаа
1	Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтанд орохын тулд кредитийн зөрүү арилгах "Нягтлан бодох бүртгэлийн мэргэшүүлэх хичээл"-ийн сургалтыг судалж, шалгалт өгөх	2-5 сар
2	Дээд газар, мэргэжлийн байгууллага болон компаниас зохион байгуулж байгаа сургалт, арга хэмжээнд оролцох.	Тухай бүр
3	Дотоод аудитын ажлын баримтууд, аудитын зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний талаарх баримтыг бүрдүүлэн архивын нэгж болгох.	Жилдээ
4	2025 оны жилийн ажлын тайлангаа Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах. 2026 оны хийх ажлын төлөвлөгөөг батлуулах.	2026 оны 1-р улиралд
5	Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Жилдээ

“ЭДЦС” ТӨХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТОРЫН 2025 ОНЫ ЯВЦЫН ТАЙЛАН

Орхон аймаг

2025. 11.30

2025 онд холбогдох хууль, тогтоомж, Эрчим хүчний сайдын 2023 оны А/271 дүгээр тушаалаар баталсан Эрчим хүчний салбарт мөрдөх дотоод аудитын аргачлал болон компанийн ТУЗ-ийн баталсан Дотоод аудиторын үйл ажиллагааны журмыг удирдлага болгон “ЭДЦС” ТӨХК-ийн дотоод дүрэм, журмын хүрээнд дотоод аудитыг зохион байгуулан ажиллаж байна.

Нэг. Төлөвлөгөөний талаар:

Дотоод аудиторын 2025 оны хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан Аудитын хороогоор хянуулан 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан.



Батлагдсан төлөвлөгөөний дагуу дотоод аудит хийх удирдамжийг Аудитын хорооны даргаар тухай бүр батлуулж, дотоод аудит хийж байна.

Хоёр. 2025 оны төлөвлөгөөний явц, үйл ажиллагааны талаар:

Компанийн дүрэм журам, стандартын мөрдөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, НББ-ийн үнэн зөв хөтлөлт, бодит байдалд аудит хийж дүгнэлт, зөвлөмж гарган компанийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх. Тус зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.





Аудит-1

• Дулааны борлуулалтын орлогод 2025 оны 1-р улирлын байдлаар дотоод аудит хийх.

• Удирдамж: 2025.04.09
• Хамрах хүрээ: СБЭЗХ, ДШС
• Хамрах хугацаа: 4,5 сар

• Асуудлын бүртгэл: 2025.06.09

• Тайлангийн төслийг бичиж аудитын хороонд танилцуулан, хянагдсан тайланг компанид хүргүүлсэн.

• Аудитаар 11 зөрчил илэрч, 11 зөвлөмж өгөв.

Аудит-2

• Шилэн дансны тухай хууль, журмын дагуу компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд бүрэн оруулсан эсэхэд аудит хийх.

• Удирдамж: 2025.07.06
• Хамрах хүрээ: СБЭЗХ, ИА, ЗУХ, ХААХ
• Хамрах хугацаа: 7,8 сар

• Асуудлын бүртгэл: 2025.08.26

• Тайлангийн төслийг бичиж аудитын хороонд танилцуулан, хянагдсан тайланг компанид хүргүүлсэн.

• Аудитаар 3 зөрчил илэрч, 4 зөвлөмж өгөв.

Аудит-3

• 2025 оны эхний хагас жилийн бараа материалын дансанд аудит хийх.

• Удирдамж: 2025.09.16
• Хамрах хүрээ: СБЭЗХ, ХААХ
• Хамрах хугацаа: 9,10 сар

• Холбогдох материалыг компаниас 2025.09.23-ны өдөр ирүүлэх байсан одоогийн байдлаар ирүүлээгүй байна.
• Аудитын хороонд 2025.09.26-ны өдөр мэдэгдсэн

• Үр дүнгүй байна.

Дотоод аудит хийхдээ “Салбарын дотоод аудитын загварын ажлын баримт”-уудыг ашиглаж байна. Аудит хийхэд шаардлагатай материалыг хугацаанд гаргаж өгөөгүйгээс хугацаа алдаж, дараагийн ажлууд хугацаанд хийгдэхгүй байх нөхцөл бүрдээд байна.

№	Аудитын нэр	Удирдамж батлагдаж, танилцуулсан огноо	Материал ирүүлэх огноо	Материал ирүүлсэн огноо
1	Дулааны борлуулалтын орлогод 2025 оны 1-р улирлын байдлаар дотоод аудит хийх.	2025.04.09	2025.04.11-15	2025.04.16-2025.05.08
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийх	2025.07.02	2025.07.08	2025.07.09-2025.08.15

3	2025 оны эхний хагас жилийн бараа материалын дансанд аудит хийх.	2025.09.16	2025.09.23	Ирүүлээгүй байна
4	Худалдан авах үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө гүйцэтгэлд, хяналт шалгалт хийж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх	2025.10.15	2025.10.20	Аудитын хийх хугацаа дууссан бөгөөд аудитын хугацаанд шаардлагатай баримт материалуудыг бүрэн ирүүлээгүй. Ирүүлсэн материалд үндэслэн дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт бусад ажил:

Биелэлтийн тухай:

Гурав. 2024 онд дотоод аудитын шалгалтаас өгсөн зөвлөмжийн биелэлтийн талаар:





Дээд газар	Хариутай бичиг болон өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь хүргүүлж ажиллав.
ТУЗ & Аудитын хороо	Өгсөн үүрэг даалгавар биелэлтийг тухай бүр нь хангаж, өгсөн зөвлөмж, чиглэлийг ажилдаа хэрэгжүүлж ажиллаж байна.
Хөндлөнгийн хяналтын баг	• Шаардлагатай тохиолдолд дотоод аудиторын хийсэн ажлыг танилцуулж, шаардлагатай материалыг бэлтгэж өгөв.
Шилэн данс	• Компанийн шилэн дансны 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1,2 дугаар улирлын тайланг цахимаар илгээв. • "Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл" гэсэн мэдээг сар бүр мэдээллэж байна.

Төлөвлөгөөт бус ажил:

Биелэлтийн тухай:

Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/109 дүгээр тушаалаар баталсан “Дулааны хэрэглэгчийн дулааны тоолуур, дулаан хангамжийн системд хяналт шалгалтыг хийх” ажлын хэсэгт ажиллаж, холбогдох дүгнэлтийг Гүйцэтгэх захиралд танилцуулсан.

ЭХЯ-аас 2025 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн в/3333 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд компанийн Гүйцэтгэх захирлын баталсан 2025 оны А/127 дугаартай тушаалаар баталсан “Ажилтан шинээр ажилд авах, сонгон шалгаруулалт явуулахад мөрдөж буй журам” нь МУ-ын Засгийн Газрын 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн хуулийн этгээдийн орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-тай нийцэж байгаа эсэхийг үнэлж, дүгнэх нийцлэлийн аудитыг хийж гүйцэтгэсэн. Тус аудитаар 3 алдаа зөрчил илрүүлж, холбогдох зөвлөмж дүгнэлтийг бичин компанид хүргүүлсэн. Үүнд:

Илэрсэн асуудал 1	Сонгон шалгаруулалтын бүх шат (зар хүргэх, материал хүлээн авах, үнэлгээ гаргах, дүн гаргах) нэг хэлтсийн хяналтад төвлөрч байгаа нь нийтлэг журмын ажлын хэсгийн хамтын хяналт, ашиг сонирхлоос ангид байх зарчимтай зөрчилдөж байна.
Зөвлөмж: ➤ Компанийн баталсан журмын 3.1 дэх заалтад “сонгон шалгаруулалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ЗУХ зохион байгуулна” гэснийг “сонгон шалгаруулалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулна” гэж засах, тус өөрчлөлттэй холбоотойгоор журмын холбогдох бусад заалтад нийтлэг журамд нийцүүлэн нэмэлт өөрчлөлтийг хийх.	
Илэрсэн асуудал 2	Компанийн баталсан журамд сонгон шалгаруулалтын зар нийтлэх сувгууд тоо нийтлэг журамд заассан тоонд хүрэхгүйгээс гадна олон нийтэд хязгаарлагдмал хүрээтэй сувгаар зарыг хүргэхээр заасан нь иргэдийн оролцоог хязгаарлах нөлөөтэй байна.

Зөвлөмж:

- Нийтлэг журмын зарчимд нийцүүлэн, компанийн баталсан журмын 4.1-дэх заалтад олон нийтэд нээлттэй шаардлага хангасан мэдээллийн сувгуудыг нэмж, журмыг шинэчлэх.

Илэрсэн асуудал 3

Компанийн баталсан журамд тусгах шаардлагатай нийтлэг журмын заалтуудыг тусгаагүй орхисон байна.

Зөвлөмж:

- Компанийн баталсан журамд нийтлэг журмын 3.3, 8.2 дох заалтуудыг нийцүүлэн тусгаж шинэчлэх.

Одоо хийгдэж буй ажил болон цаашид хийгдэхээр хүлээгдэж буй ажлууд:

- “Худалдан авах үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө гүйцэтгэлд, хяналт шалгалт хийж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх” энэхүү аудитын ажил тайлан боловсруулах шатандаа явж байна.
- Удирдамж нь батлагдсан “2025 оны эхний хагас жилийн бараа материалын дансанд аудит хийх” ажил хийгдэхээс гадна дараах ажлууд хүлээгдэж байна. Компаниас аудит хийх боломжит материалыг ирүүлээгүй учир аудитын ажил хийгдэхгүй хүлээгдэж байна.

Шилэн дансны тухай хууль, журмын дагуу компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн сайтад бүрэн оруулсан эсэхэд аудит хийх.

2025 оны сүүлийн 6 сар

20 хоног



2025 оны жилийн санхүү балансын тайланд аудит хийх.

2025 оны 12 сар, 2026 оны 1,2 сард

60 хоног

ДОТООД АУДИТОР

БАТЛАВ
“ЭДЦС” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА /Д.БАТЗОРИГ/



ДОТООД АУДИТОРЫН 2024 ОНД
ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр

Орхон аймаг

1. Аудит, хяналт шалгалт хийх үндэслэл:

Монгол Улсын Төрийн аудитын тухай, Төрийн хянан шалгалтын тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Эрчим хүчний тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.1, болон компанийн дүрэм, компанийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг тус тус үндэслэн батлагдсан төлөвлөгөөт хуваарийн дагуу дотоод аудитыг явуулна.

2. Аудит, хяналт шалгалтын зорилго:

Компанийн санхүүгийн үйл ажиллагаа нь Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, заавар журам, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцэж байгаа эсэх, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан дүрэм, журмуудын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж дүгнэлт гарган илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж бичиж хүргүүлэхэд оршино.

3. Аудит, хяналт шалгалтын хамрах хүрээ:

Аудит, хяналт шалгалтыг Компанийн 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сар хүртэлх хугацааг хамруулна.

4. Шалгах ажлын чиглэл:

№	Хамрагдах алба, хэлтэс, цех	Ажлын хамрах хүрээ	Эрсдлийн үнэлгээ	Хийх хугацаа	Гүйцэтгэх хоног
1	ЗУХ, СБЭЗХ, ХААХ	Шилэн дансны тухай хууль, журмын дагуу компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн сайтад бүрэн оруулсан эсэхэд аудит хийх.		Улирал тутам	20 хоног

2	ЗУХ, СБЭЗХ	Гүйцэтгэх захирлын 2024 оны тушаал шийдвэрийн хэрэгжилтэд түүврийн аргаар аудит хийх.		6,12 сар	20 хоног
3	Бүх нэгжүүд	2023 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын газар болон бусад хяналт шалгалтаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт хийх.		6-7 сар, 10 сар	20 хоног
4	СБЭЗХ	Санхүү балансын тайланд дүн шинжилгээ хийх.		8, 1-2 сар	25 хоног
5	ХААХ	Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэлд, хяналт шалгалт хийж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх.		8,1 сар	25 хоног
6	СБЭЗХ	Компанийн ажилтнуудын ажлын цаг ашиглалт, цаг бүртгэлийн үйл ажиллагаанд аудит хийх.		9-10 сар	20 хоног
7	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх			Тухай бүрт	20 хоног

5. Сургалт ба хөгжүүлэлт

Дотоод аудит нь ажлын ур чадвартай байх, мэргэжлээ тасралтгүйгээр хөгжүүлэх замаар мэдлэг ур чадвар, бусад чадвараа сайжруулах, хамгийн сүүлийн үеийн хөгжил дэвшлийг даган хөгжиж байх ёстой гэж заасан үндэслэн сургалт хөгжүүлэлтийн төлөвлөгөө гаргалаа.

№	Сургалт хөгжүүлэлт	Хугацаа
1	ISO27001:2021 мэдээллийн технологи, Аюулгүй байдлын арга техник, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх төслийн багт ажиллаж, тус стандартыг нэвтрүүлэхдээ холбоотой өөрийн ажлын байрны мэдээллийн аюулгүй байдлын мэдээллийн урсгал, үр нөлөөг тодорхойлох	4-10 сар
2	Монголын татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгээс зохион байгуулдаг татварын мэргэшсэн зөвлөхийн сорил болон эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтад хамрагдах, сорил шалгалт өгөх.	4-6 сар
3	Дээд газар, мэргэжлийн байгууллага болон компаниас зохион байгуулж байгаа сургалт, арга хэмжээнд оролцох.	Тухай бүр

3	Дээд газар, мэргэжлийн байгууллага болон компаниас зохион байгуулж байгаа сургалт, арга хэмжээнд оролцох.	Тухай бүр
---	---	-----------

6. Бусад

1	Эрчим хүчний салбарын спортын их наадамд сагсан бөмбөг, волейболын төрөлд оролцох.	5 сар
2	Шилэн дансны тухай журмыг шинэчлэн боловсруулах, Гүйцэтгэх захиралд танилцуулж батлуулах.	5-6 сар
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитын ажиллах журам боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.	9-10 сар
4	Дотоод аудитын ажлын баримтууд, аудитын зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний талаарх баримтыг бүрдүүлэн архивын нэгж болгох.	Жилдээ
5	Компанийн нэгж хэсэгт хийгдсэн эрсдэлийн үнэлгээтэй танилцах, эрсдэлийн үнэлгээ хийх ажилд идэвх санаачилгатай оролцох	10-12 сар
6	2024 оны жилийн ажлын тайлангаа Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах. 2025 оны хийх ажлын төлөвлөгөөг батлуулах.	2025 оны 1-р улиралд

ХЯНАСАН:

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

Ч.БАТТУЯА

ТАНИЛЦСАН:

“ЭДЦС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БАТ-ЭРДЭНЭ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ДОТООД АУДИТОР

Б.ГАНЧИМЭГ

“ЭДЦС” ТӨХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТОР Б.ГАНЧИМЭГИЙН 2024 ОНЫ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025 он

ОРХОН АЙМАГ

2024 онд холбогдох хууль, тогтоомж, Эрчим хүчний сайдын 2023 оны А/271 дүгээр тушаалаар баталсан Эрчим хүчний салбарт мөрдөх дотоод аудитын аргачлал, салбарын дотоод аудитын загварын ажлын баримтыг удирдлага болгон “ЭДЦС” ТӨХК-ийн дотоод дүрэм, журмын хүрээнд дотоод аудитыг зохион байгуулж ажиллалаа.

Нэг. Удирдлага зохион байгуулалтын ажлын талаар:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 07, 08 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудиторт хүүхэд асрах эхийн чөлөө олгож ажлаас түр чөлөөлж, түүний оронд дотоод аудитораар түр томилогдон ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын 2024 оны А/128, 158 дугаартай тушаалын дагуу 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр өмнөх ажлыг хүлээлцүүлэн, 4 дүгээр сарын 19-ний өдөр Дотоод аудиторын ажлыг хүлээн авсан.

Дотоод аудиторын 2024 оны хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдөр ТУЗ-ийн дарга баталсан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу дотоод аудит хийх удирдамжийг Аудитын хорооны даргаар тухай бүр батлуулж, дотоод аудит хийж, зөвлөмж, дүгнэлт өгч, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд аудит хийж ажиллалаа.

Хоёр. 2024 оны төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны талаар:

Компанийн дүрэм журам, стандартын мөрдөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт, НББ-ийн үнэн зөв хөтлөлт, бодит байдалд аудит хийж дүгнэлт, зөвлөмж гарган компанийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

Тус зорилтын хүрээнд дараах аудитыг хэрэгжүүлж үнэлэлт, дүгнэлт зөвлөмж өгсөн байна.

2024 оны ажлын төлөвлөгөөний хамрах хугацаа 2024 оны 05 дугаар сараас 2025 оны 02 дугаар сар хүртэл.

№	Хамрах хүрээ	Дотоод аудит хийх ажлын чиглэл	Биелэлтийн тухай (товч)
Аудит:			
1	ЗУХ, СБЭЗХ, ХААХ	Шилэн дансны тухай хууль, журмын дагуу компанийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн сайтад бүрэн оруулсан эсэхэд аудит хийх.	2024.08.19-ний өдрийн батлагдсан удирдамжийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2024 оны эхний 7-н сарын байдлаар дотоод аудит хийв. 1 зөрчлийг илрүүлж, холбогдох зөвлөмж, дүгнэлтийг өгөв. 2025.01.21-ний өдрийн батлагдсан удирдамжийн дагуу 8-12 сарын мэдээллийг цахим хуудсанд мэдээлэл байршуулсан талаар зөвлөмж өгөв. 2 зөрчлийг илрүүлж, холбогдох зөвлөмж, дүгнэлтийг өгөв.
2	ЗУХ, СБЭЗХ	Гүйцэтгэх захирлын 2024 оны тушаал шийдвэрийн хэрэгжилтэд түүврийн аргаар аудит хийх.	2024.06.17-ны өдрийн батлагдсан удирдамжийн дагуу Гүйцэтгэх захирлын 2024 оны эхний 5-н сарын байдлаар дотоод аудит хийв. 10 алдаа, зөрчлийг илрүүлж, холбогдох зөвлөмж, дүгнэлтийг өгөв.
3	ХААХ	Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэлд, аудит хийж, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх.	2024.10.03-ны өдрийн батлагдсан удирдамжийн дагуу 2024 оны III улирлын байдлаар ХАА-нд түүврийн аргаар аудит хийв. Аудитаар 13 алдаа, зөрчлийг илрүүлж холбогдох зөвлөмж, дүгнэлтийг өгөв.
4	Холбогдох нэгжүүд	2023 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус аудитын газар болон бусад хяналт шалгалтаас өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт хийх.	2023 онд хөндлөнгийн 3 хяналт шалгалт ирсэн. Үүнд: <u>ТӨБЗГ:</u> Компанийн 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж биелэлтийг ТӨБЗГ-т хүргүүлсэн. Мөн хэрэгжилтийг ТУЗ-ийн 2024 оны 10 дугаар сарын хуралд тайлагнасан. <u>ЭХЯ:</u> Компанийн 2022 он, 2023 оны III улирлын байдлаар санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, ИЗ, ТЗБАХ, ХО, санхүүгийн дотоод хяналтын хэрэгжилтэд хийсэн дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд аудит хийж, биелэлтийг ЭХЯ-д хүргүүлсэн. <u>Төрийн аудит:</u> Компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаас өгсөн албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд аудит хийж биелэлтийг ЭХЯ-д хүргүүлсэн. Мөн хэрэгжилтийг ТУЗ-ийн 2024 оны 10 дугаар сарын хуралд танилцуулж, тайлагнасан. Дээрх хөндлөнгийн хяналт шалгалтаас өгсөн хэрэгжилтээс бүрэн хангагдаагүй үүрэг даалгавар, зөвлөмжийг нэгтгэн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг Гүйцэтгэх захиралд танилжуулж ажиллав.
5	СБЭЗХ	2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх.	Төлөвлөгөөний дагуу холбогдох удирдамжийг боловсруулан аудитын хороонд танилцуулсан. Аудитыг 2025.02.24-ны өдрөөс 2025 оны 1-р дүгээр улирал хүртэл хийж дуусгахаар төлөвлөж байна.

6	СБЭЗХ	Компанийн ажилтнуудын ажлын цаг ашиглалт, цаг бүртгэлийн үйл ажиллагаанд аудит хийх.	Энэ ажил хийгдээгүй, хугацааны хувьд амжсангүй. 2025 оны хийх ажлын төлөвлөгөөнд шилжүүлж аудит хийхээр тусгалаа.
Сургалт хөгжүүлэлт ба бусад			
1	ISO27001:2021 мэдээллийн технологи, Аюулгүй байдлын арга техник, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх төслийн багт ажиллаж, тус стандартыг нэвтрүүлэхдээ холбоотой өөрийн ажлын байрны мэдээллийн аюулгүй байдлын мэдээллийн урсгал, үр нөлөөг тодорхойлох		ISO27001:2021 мэдээллийн технологи, Аюулгүй байдлын арга техник, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог компанид нэвтрүүлэх төслийн багт ажиллаж байна. Компанийн ИТА-аас эрсдэлийг бичүүлж түүнийг аргачлалын дагуу боловсруулав, мөн стандартын шаардлагад туссан эрсдэлүүдээс компанид хамааралтай эрсдэлийг тодорхойлж тус стандартын дагуу түүнд боловсруулт хийв. МАБ-ын эрсдэлийг тодорхойлж үнэлж, дүгнэх багийг ахлан ажилласан.
2	Монголын татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгээс зохион байгуулдаг татварын мэргэшсэн зөвлөхийн сорил болон эрх олгох шалгалтад бэлтгэх сургалтад хамрагдах, сорил шалгалт өгөх.		Монголын татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгээс зохион байгуулдаг татварын мэргэшсэн зөвлөхийн сорил шалгалтад бэлтгэх сургалтад хамрагдсан, сорил шалгалт өгч тэнцсэн.
3	Дээд газар, мэргэжлийн байгууллага болон компаниас зохион байгуулж байгаа сургалт, арга хэмжээнд оролцох.		Дээд газар болон мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтад тухай бүрд хамрагдаж байна.
4	Эрчим хүчний салбарын спортын их наадамд сагсан бөмбөг, волейболын төрөлд оролцох.		Хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг Эрчим хүчний салбарын спортын их наадамд 2024 онд зохион байгуулагдсан. Тус тэмцээнд сагсан бөмбөг, волейбол гэсэн төрлөөр оролцсон.
5	Шилэн дансны тухай журмыг шинэчлэн боловсруулах, Гүйцэтгэх захиралд танилцуулж батлуулах.		Компанийн “Шилэн данс, мэдээллийн самбарын үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай журам”-ын төслийг боловсруулж, Гүйцэтгэх захиралд танилцуулж хүлээлгэн өгсөн.
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитын ажиллах журам боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.		ТУЗ-ийн дэргэдэх “Дотоод аудиторын үйл ажиллагааны журам”-ын төслийг боловсруулж, аудитын хороонд танилцуулж ТУЗ-ийн 2024.12.30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх материалыг бэлтгэн танилцуулж, батлуулсан.
7	Дотоод аудитын ажлын баримтууд, аудитын зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний талаарх баримтыг бүрдүүлэн архивын нэгж болгох.		Дотоод аудитын ажлын баримтууд, аудитын зөвлөмжийн мөрөөр авсан арга хэмжээний талаарх баримт, тайланд хугацаанд хийсэн ажлын тайлан бусад баримт бичгүүдийг бүрдүүлэн архивын нэгж болгон хугацаанд нь буюу 2025.03.31-ний дотор компанийн архивд хүлээлгэн өгнө.
8	Компанийн нэгж хэсэгт хийгдсэн эрсдэлийн үнэлгээтэй танилцах, эрсдэлийн үнэлгээ хийх ажилд идэвх санаачилгатай оролцох		2024 оны байдлаар компанийн хэмжээнд нэгдсэн эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй байна. ХАБ-ын эрсдэлийг тодорхойлж үнэлсэнтэй танилцсан. ISO27001:2021 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог компанид нэвтрүүлэх төслийн багт ажиллахдаа МАБ-ын эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах ажлыг хэсгийг ахлаж ажиллаж байна. Тус ажил 2025 оны нэг дүгээр улиралд хугацаанд хүлээлгэн өгч дуусгана.

9	2024 оны жилийн ажлын тайлангаа Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах. 2025 оны хийх ажлын төлөвлөгөөг батлуулах.	Дотоод аудитын 2024 оны ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулсан. 2024 оны жилийн ажлын тайлангаа бэлтгэн аудитын хороонд танилцуулсан. ТУЗ-д тайлагнахаар бэлдэж байна. 2025 оны хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж аудитын хороонд танилцуулсан, ТУЗ-д танилцуулж батлуулахаар материалыг бэлдэж байна.
---	--	--

(Батлагдсан удирдамжийн дагуу дотоод аудит хийсэн тайлангуудыг хавсаргав)

Гурав. Бусад хийгдсэн ажлын талаар:

- ❖ 2024 онд хөндлөнгийн хяналт шалгалтаар ирсэн багт дотоод аудиторын ажлыг танилцуулж, шаардлагатай материалуудыг өгч ажиллалаа.
- ❖ ЭХЯ болон “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК хамтран 2024 оны 09 дүгээр сард 2 өдрийн хугацаатай зохион байгуулсан Эрчим хүчний салбарын дотоод аудиторуудын зөвлөгөөнд оролцсон.
- ❖ Дээрх зөвлөгөөнөөс “ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны журамд нэмэлт өөрчлөлт оруулах” гэсэн зөвлөмжийг компанийн ТУЗ-д өгсөн. ЭХЯ-аас тус зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллахыг албан бичгээр ирүүлсэн. Үүний хүрээнд Аудитын хорооны үйл ажиллагааны журамд дотоод аудитортой холбоотой өөрчлөлтийг оруулах саналаа өгч, аудитын хороонд танилцуулсан. Тус асуудлыг ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын хурлаар хэлэлцэн баталж, ЭХЯ-аас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн.
- ❖ Дотоод аудиторын ажлын байрны тодорхойлолтыг холбогдох дүрэм журмын дагуу боловсруулж, Аудитын хороогоор хянуулж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулав.
- ❖ Мөн салбарын дотоод аудиторуудаас туршлага судалж, Дотоод аудиторын сарын болон жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсний шалгуур үзүүлэлтийг боловсруулж Аудитын хороонд танилцуулан хянуулж, ТУЗ-ийн хуралд танилцуулж албажуулав.
- ❖ Дээд газраас ирүүлсэн хариутай бичгийг хугацаанд хүргүүлсэн.
- ❖ ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар 2020 оноос 2024 оны 11 сарын 15 хүртэл ажилласан. Тайлант хугацаанд батлагдсан хуваарийн дагуу хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох мэдээллүүдийг бэлтгэн гишүүд болон ЭХЯ-д хүргүүлж, нийт 15 удаагийн хурлыг цахим болон танхимаар зохион байгуулж 15 хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл бичиж, хэлэлцэх асуудалтай холбоотой 9 тэмдэглэл, 22 тогтоолын төслийг боловсруулж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажилласан. Мөн 2024 оны ХЭХ-ын бэлтгэл ажлыг хангаж, хурлаар 6 асуудлыг хэлэлцэж, 6 тогтоол батлагдсан.

ТУЗ-ийн нарийн бичгийн ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр комисст хүлээлгэн өгөв.

Дөрөв. Цаашид тавих зорилт:


- ❖ 2025 онд дотоод аудитаас өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг бүрэн хангуулахад анхаарч ажиллана.
- ❖ Мэргэжлийн ур чадвартай байх үүднээс мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлнэ.
- ❖ Дотоод аудиторын дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, батлуулах.

Тав. Санал, хүсэлт:

- ❖ Цалингийн түвшинг нэмэгдүүлэх саналтай байна. (Хүсэлтийг хавсралтаар хүргүүлэв)

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР:

G. 

Б.ГАНЧИМЭГ

Мэдээлэл оруулсан: Дотоод аудитор Б.Ганчимэг

Цахим хаяг, утас: Chingee.4050@gmail.com, Утас: 94094050

Ажлын байрны хаяг: ЭДЦС ТӨХК 4 давхарт, 420 тоот



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.14 № 149
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**2024 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар 741.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 26.2 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 705.6 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 9.6 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмжийг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/004/НА-СТА-ТӨҮГ

Цахим www.audit.mn Эрдэнэт хот 2024 он	хуудас: Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болормаа Утас: 70350757 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn Аудитор: Ц.Одгэрэл Утас: 70350757 Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn Аудитор: Ж.Наранчимэг Утас: 70350757 Цахим хаяг: naranchimegi@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.14 № 87
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 03/8300 дугаарын албан бичгээр “Эрчим хүчний сайд”-аас 66 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа төслийн санхүүжилтийг дуусгах зорилгоор зээл авахад татгалзах зүйлгүй гэсний дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 28 дугаар тогтоолоор “Компанийн Үнсэн сан хоослох” ажлыг санхүүжүүлэх зорилгоор Голомт банкнаас 5,000.0 сая төгрөгийн зээл авч, 2024 оны эцсийн байдлаар 2,000.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Эрчим хүчний сайдын тушаалаар Эрдэнэтийн дулааны станц ТӨХК-ийн 2024 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 83,309.6 сая төгрөг, зардлыг 95,185.4 сая төгрөг, алдагдлыг 11,875.8 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Гүйцэтгэлээр 90,640.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 90,326.7 сая төгрөгийн зардал гаргаж, 313.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Их засвар, хөрөнгө оруулалтын 12,729.9 сая төгрөгийн 137 ажлыг төлөвлөснөөс 127 төсөл арга хэмжээг 7,637.3 сая төгрөгөөр санхүүжүүлж, нийт хөрөнгө оруулалтын ажил 92.5 хувийн гүйцэтгэл байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй зээлээр барьсан хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөж, Эрчим хүчний сайдын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/273 дугаар тушаалаар улсын комисс томилогдон 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн “Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс” -ын дүгнэлт гарснаас хойш 2-3 жил ашиглаж байгаа ч одоог хүртэл хэрхэн бүртгэх талаар тодорхой шийдвэр ирээгүй хэвээр байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12 -р сарын 31
А	А	1	2
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	523,280,011.30	1,127,762,713.71
1.1.2	Дансны авлага	3,923,726,572.30	5,254,108,740.61
1.1.3	Татвар НДШ-ийн авлага	444,512,801.78	350,526,126.46
1.1.6	Бараа материал	4,525,815,010.95	5,452,218,624.85
1.1.7	Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	1,096,122,158.53	179,781,771.23
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	10,513,456,554.86	12,364,397,976.86
1.2.1	Үндсэн хөрөнгө	67,242,241,125.89	69,516,309,807.94
1.2.2	Биет бус хөрөнгө	21,071,534,516.60	21,192,520,530.22
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	88,313,775,642.49	90,708,830,338.16
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	98,827,232,197.35	103,073,228,315.02
2.1.1.1	Дансны өглөг	3,628,928,183.21	8,380,580,415.10
2.1.1.2	Цалингийн өглөг	2,523,857,334.31	4,042,361,898.51
2.1.1.3	Татварын өр	573,760,864.87	193,021,179.60
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	1,600,000,000.00	2,000,000,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	48,456,956.35	61,216,936.57
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,211,356,712.69	855,273,171.00
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,586,360,051.43	15,532,453,600.78
2.1.2.1	Урт хугацаат зээл	2,000,000,000.00	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	741,907,519.22	807,716,570.81
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,741,907,519.22	807,716,570.81
2.3.1	Өмч: а) төрийн	19,447,456,792.53	19,447,456,792.53
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	59,135,050,898.37	59,135,050,898.37
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	20,937,713,000.00	21,055,553,000.00
2.3.9.	Хуримтлагдсан ашиг	(13,021,256,064.20)	(12,905,002,547.47)
2.3.20	Эздийн өмчийн дүн	86,498,964,626.70	86,733,058,143.43
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	98,827,232,197.35	103,073,228,315.02

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	83,351,247,360.11	83,692,225,663.70
2	Борлуулалтын өртөг	72,560,402,640.13	80,828,099,064.91
3	Нийт ашиг (алдагдал)	10,790,844,719.98	2,864,126,598.79
4	Түрээсийн орлого	36,657,360.00	35,371,178.18
5	Хүүгийн орлого	5,727,669.89	23,758,251.21
8	Бусад орлого	1,486,338,112.05	6,888,782,971.81
9	Борлуулалт, маркетингийн зардал	5,628,241,009.63	6,663,214,695.22
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,592,582,447.63	1,794,644,998.85
12	Бусад зардал	1,584,570,064.36	1,040,756,988.25
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(17,154,593.45)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	3,497,019,746.85	313,422,317.67

19	Орлогын татварын зардал	493,109,172.40	46,973,272.22
20	Татварын дараах ашиг /алдагдал/	3,003,910,574.45	266,449,045.45
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	3,003,910,574.45	266,449,045.45
24	Орлогын нийт дүн	3,003,910,574.45	266,449,045.45
25	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	7.72	0.69

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000	(16,025,166,638.65)	83,495,054,052.25
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		-	3,003,910,574.45	3,003,910,574.45
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000	(13,021,256,064.20)	86,498,964,626.70
11	Залруулсан үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000	(13,021,256,064.20)	86,498,964,626.70
2	Бусад дэлгэрэнгүй орлого	-		117,840,000	-	117,840,000.00
8	Тайлант үеийн цэвэр ашиг	-		-	266,449,045.45	266,449,045.45
9	Ногдол ашиг	-			(150,195,528.72)	(150,195,528.72)
11	2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	21,055,553,000	(12,905,002,547.47)	86,733,058,143.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	75,060,865,063.17	83,918,690,229.88
1.1.1.	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	75,005,021,549.17	76,952,352,522.28
1.1.5.	Татаас, санхүүжилтийн орлого		6,564,860,000.00
1.1.6.	Бусад мөнгөн орлого	55,843,514.00	401,477,707.60
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(67,962,886,114.54)	(75,078,741,467.46)
1.2.1.	Ажиллагчдад төлсөн	(11,668,986,709.60)	(18,818,997,985.23)
1.2.2.	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(4,267,500,000.00)	(5,653,585,722.80)
1.2.3.	Бараа материал худалдан авахад төлсөн	(40,717,804,668.95)	(37,478,790,788.36)
1.2.4.	Ашиглалтын зардалд төлсөн	(168,915,474.00)	(157,862,794.74)
1.2.5.	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(6,046,450,864.87)	(7,049,879,466.23)
1.2.6.	Хүүний төлбөрт төлсөн	(41,187,945.21)	(617,095,030.75)
1.2.7.	Татварын байгууллагад төлсөн	(3,816,294,598.79)	(4,789,083,818.83)
1.2.8.	Даатгалын төлбөрт төлсөн	(11,991,239.01)	(11,202,256.00)
1.2.9.	Бусад мөнгөн зарлага	(1,223,754,614.11)	(502,243,604.52)

1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,097,978,948.63	8,839,948,762.42
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,976,669.89	23,758,251.21
2.1.6.	Хүлээн авсан хүүний орлого	5,976,669.89	23,758,251.21
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(10,256,228,611.99)	(6,509,028,782.50)
2.2.1.	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(10,256,228,611.99)	(6,509,028,782.50)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,250,251,942.10)	(6,485,270,531.29)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,600,000,000.00	1,400,000,000.00
3.1.1.	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,600,000,000.00	1,400,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	(3,150,195,528.72)
3.2.1.	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		(3,000,000,000.00)
3.2.4.	Төлсөн ногдол ашиг		(150,195,528.72)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,600,000,000.00	(1,750,195,528.72)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	447,727,006.53	604,482,702.41
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	75,553,004.77	523,280,011.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	523,280,011.30	1,127,762,713.71

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Хэмжих нэгж	2024 оны тодотгосон төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	2024 Гүйц - 2024 Төлөв	Биелэлт
			х	2	3	4=3-2	
1	Үйлдвэрлэсэн: Цахилгаан эрчим хүч		мян.квтц	437,748.0	432,132.0	(5,616.0)	98.7%
	Үйлдвэрлэсэн: Дулааны эрчим хүч		Гкал	700,000.0	699,590.0	(410.0)	99.9%
	ДХЦЭХ	Хувиар	хувь	13.46%	13.59%	0.14%	99.0%
		Биетээр	мян.квтц	58,900.5	58,739.1	(161.4)	100.3%
	Түгээсэн: Цахилгаан эрчим хүч		мян.квтц	378,847.5	373,392.9	(5,454.7)	98.6%
	Түгээсэн: Дулааны эрчим хүч		Гкал	646,949.3	647,002.0	52.7	100.0%
2	Нийт орлого		мян.төг	83,309,603.9	90,640,138.0	7,330,534.2	108.8%
	Үүнээс:	Цэвэр борлуулалт	мян.төг	81,842,099.9	83,692,225.6	1,850,125.8	102.3%
		Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	1,467,504.0	6,947,912.4	5,480,408.4	473.5%
3	Нийт зардал		мян.төг	95,185,403.8	90,326,715.7	(4,858,688.0)	105.4%
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	мян.төг	93,205,849.7	89,283,671.4	(3,922,178.3)	104.4%
		Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	1,979,554.1	1,043,044.4	(936,509.7)	189.8%
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		мян.төг	(11,875,799.9)	313,422.3	12,189,222.2	2.6%
5	Татварын дараахь ашиг/алдагдал		мян.төг	(11,875,799.9)	266,449.0	12,142,248.9	2.2%

6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төг	1.14	1.00	(0.15)	114.7%
7	Нийт авлага		мян.төг	5,683,600.0	5,604,634.9	(78,965.1)	101.4%
	Үүнээс:	ЭХ-ний	мян.төг	4,118,000.0	4,500,096.3	382,096.3	91.5%
		бусад	мян.төг	1,565,600.0	1,104,538.6	(461,061.4)	141.7%
8	Нийт өглөг		мян.төг	213,129,500.0	16,340,170.2	(196,789,329.8)	7.7%
	Үүнээс: өр төлбөр	Богино хугацаат	мян.төг	32,268,800.0	15,532,453.6	(16,736,346.4)	48.1%
		Урт хугацаат	мян.төг	180,860,700.0	807,716.6	(180,052,983.4)	44.6%
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	465	465	0	100.0%
10	Нийт цалингийн сан		мян.төг	21,162,722.6	22,608,260.5	1,445,537.9	93.6%
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	ЦЭХ	гр/кВт.ц	423.67	415.25	(8.4)	102.0%
		ДЭХ	кг/Гкал	188.00	189.08	1.1	99.4%
12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		мян.төг	12,729,921.2	7,637,325.6	(5,092,595.6)	92.2%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн зорилго нь хэрэглэгчийг дулаан, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан үйлдвэрлэх;
- Дулаан үйлдвэрлэх;
- Дулаан түгээх;
- Дулаанаар зохицуулалттай хангах;
- Эрчим хүчний тоног төхөөрөмж, даралтат сав шугам хоолойг ашиглах, засвар үйлчилгээ хийх;
- Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компанийн статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 70 хувь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 30 хувийг эзэмшиж байна.

Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 12 зорилтын хүрээнд төлөвлөснөөс 4 үзүүлэлт давж, 5 үзүүлэлт бүрэн хэрэгжиж, 3 үзүүлэлт 92-99 хувьтай биелж, нийт 100.0 хувийн биелэлттэй байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийг Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 164 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулж, компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилдог байна.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сард 0.9-1.2 сая төгрөгөөр тогтоосон байна.

Тус байгууллага нь тайланд онд үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- Компанийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын тухай багц хууль,
- Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн тогтох тухай",
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дугаар тушаал "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам",
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаал "Дундаж цалин хөлс тодорхойлох журам".

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 3 удаагийн нэмэлт өөрчлөлт,Хөдөлмөрийн тухай хуульд 2 удаагийн нэмэлт өөрчлөлт,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаагийн нэмэлт өөрчлөлт,
- Компанийн тухай хуульд 4 удаагийн нэмэлт өөрчлөлт,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 1 удаагийн нэмэлт өөрчлөлт тус тус орсон байна.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн ТУЗ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор ТУЗ-ын дэргэдэх "Дотоод аудитын үйл ажиллагааны журам"-ыг баталсан байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд тус компанийн бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл болон санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд байгууллага Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 онд баталсан бөгөөд тухайн үед мөрдөгдөж байсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа хэдий ч 2016-2024 онд шинэчлэгдсэн хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,426.0 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	523.30	1,127.80	604.50
Авлага	4,368.20	5,604.60	1,236.40
Бараа материал	4,525.80	5,452.20	926.40

Урьдчилж төлсөн тооцоо	1,096.10	179.80	(916.30)
Үндсэн хөрөнгө	88,313.80	90,708.80	2,395.00
Нийт хөрөнгө	98,827.20	103,073.20	4,246.00
Өр төлбөр	12,328.20	16,340.20	4,012.00
Эздийн өмч	86,499.00	86,733.10	234.10
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	98,827.20	103,073.30	4,246.10

Нийт хөрөнгө өмнөх оноос 4,246.0 сая төгрөгөөр өсөхөд мөнгөн хөрөнгө 604.5 сая, авлага 1,236.4 сая, бараа материал 926.4 сая төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,127.8 сая төгрөг болж, өмнөх оноос 604.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст Диспетчерийн үндэсний төвөөс 1,042.0 сая төгрөг шилжин орсон нь гол нөлөө үзүүлсэн байна. Арилжааны 6 банк дахь харилцах дансны үлдэгдэл 1,127.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 5,604.6 сая төгрөг болж, өмнөх оноос 1,236.4 сая төгрөгөөр өсөхөд Диспетчерийн үндэсний төв ХХК-д худалдсан цахилгаан эрчим хүчний авлага 4,334.6 сая төгрөг буюу 77.3 хувийг эзэлж буй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Дулааны эрчим хүчний авлага 141.9 сая буюу нийт авлагын 2.5 хувь, татвар НДШ-тэй холбоотой авлага 911.6 сая төгрөг буюу 16.3 хувь, бусад авлага нь 190.7 сая төгрөг буюу 3.4 хувийг тус тус эзэлж байна.

Санхүүгийн тайланд бүртгэлтэй 5,604.6 сая төгрөгийн авлагаас насжилтаараа 3 ба түүнээс дээш жил болсон 23.7 сая төгрөгийг "Айда" ХХК, "Орхон хүнс" ХХК-ийн авлага нь нийт авлагын 0.4 хувийг эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5,452.2 сая төгрөг болж, өмнөх оноос 926.4 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 46,336.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 45,409.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 27 дугаар тогтоолоор компанийн үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай байдлыг хангах зорилгоор аюулгүйн нөөцийг бүрдүүлж, 3,050.2 сая төгрөгийн бараа материалыг бүртгэсэн нь гол нөлөөлсөн байна.

Урьдчилж төлсөн төлбөрийн данс 179.8 сая төгрөг болж, 916.3 сая төгрөгөөр буурсан нь Диспетчерийн үндэсний төвийн хоорондын тооцоогоор Монголын төмөр замын нүүрсний тээврийн төлбөрийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 90,708.8 сая төгрөг болж, өмнөх оноос 2,395.0 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд шинээр 6,731.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 12,712.5 сая төгрөгийн барилга байгууламжийг угсарч суурилуулж, ТӨБЗГ-ын 442 дугаар тогтоолоор 133.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, А-1/853 зөвшөөрлийн дагуу 1,589.6 сая төгрөгийн хөрөнгийг машин тоног төхөөрөмжийн данснаас тээврийн хэрэгслийн дансанд шилжүүлж, 764 дүгээр тогтоолоор 218.9 сая төгрөгийн 46 ширхэг хөрөнгийг акталсан байна.

Дуусаагүй барилга данс 1,613.1 сая төгрөг болж, 10,067.1 сая төгрөгөөр буурсан нь он дамжин хэрэгжиж буй их засварын ажлаас хөрөнгөд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 15,532.5 сая төгрөг болж 5,946.1 сая төгрөгөөр өссөн байна. Дансны өглөг 8,380.6 сая төгрөг, цалингийн өглөг 4,042.4 сая төгрөг, татварын өр төлбөр 193.0 сая төгрөг, богино хугацаат зээл 2,000.0 сая төгрөг, урьдчилж орсон

орлого 61.2 сая төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 855.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тооцооны үлдэгдлийн баталгааны нотлох баримт хангалтгүй байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 807.7 сая төгрөг болж 65.8 сая төгрөгөөр өссөн нь хойшлогдсон орлогоор бүртгэсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 8,155.5 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээний ажлын үлдэгдэл байна.

Санхүүгийн тайланд бүртгэлтэй нийт өглөгөөс 1 жил хүртэлх насжилттай 39 харилцагчийн 500.6 сая төгрөг, 1-2 жилийн насжилттай 7 харилцагчийн 48.4 сая төгрөг, 2-3 жилийн насжилттай 10 харилцагчийн 39.4 сая төгрөг, 3 ба түүнээс дээш жилийн насжилттай 12 харилцагчийн 21.4 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад 8,943.8 сая төгрөгөөр өссөн нь цалин, НДШ-ийн зардал, түлшний зардал, борлуулалтын шимтгэлийн зардлууд нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа нийт орлогыг 83,309.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 95,185.4 сая төгрөгөөр, 11,875.8 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 11,175.5 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Эрчим хүчний сайдын 2024 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн А/164 дүгээр тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодотгохдоо хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтын ажлын нэрийг өөрчилсөн бол Эрчим хүчний сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/293 дугаар тушаалаар 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодотгохдоо нийт орлогыг 83,309.6 сая төгрөг, зардлыг 95,185.4 сая төгрөг, алдагдлыг 11,875.8 сая төгрөг байхаар төлөвлөж, хөрөнгө оруулалтын арга хэмжээг 1,554.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 12,729.9 сая төгрөг болгон тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 90,640.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 90,326.7 сая төгрөгийн зардал гарган, 313.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тайлант онд 11,875.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн хэдий ч 313.4 сая төгрөгийн ашигтай ажилласан нь зардлыг төлөвлөснөөс 4,858.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт орлогын гүйцэтгэл 90,640.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 7,330.5 сая төгрөг буюу 8.8 хувиар давсан нь Эрчим хүчний яамны санхүүжилт 6,564.8 сая төгрөг орж, үйл ажиллагааны бус орлого давсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 90,326.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 4,858.7 сая төгрөг буюу 5.4 хувийн дутуу гүйцэтгэлтэй байна.

Энэ нь тайлант оны үйлдвэрлэлийн хэмжээний өсөлттэй холбоотойгоор 24 нэр төрлийн зардлаас 13 нэр төрлийн зардлыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна. Тухайлбал: туслах материал 312.8 сая, шатахуун 410.0 сая, ус 1,158.4 сая, элэгдлийн зардал 4,532.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны А/01-ны өдрийн тогтоолын 2 дугаар хавсралтаар хөрөнгө оруулалтын 136 ажлыг 11,175.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг баталсан байна.

Эрчим хүчний сайдын 2024 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн А/164 дүгээр тушаалаар хөрөнгө оруулалтын 136 ажлыг 11,175.5 сая төгрөг болгон тодотгосон бол 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/293 дугаар тушаалаар 12,729.92 сая төгрөгийн 137 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус тодотгосон байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл /сая.төгрөг/						
д/д	Зардлын төрөл	2024 оны төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт
		тоо	сая.төг	тоо	сая.төг	хувь
1	Их засварын ажил	50	7,556.4	41	4,777.4	90.7%
2	Техник зохион байгуулалтын арга хэмжээ	10	1,267.0	10	1,182.3	100.0%
3	Хөрөнгө оруулалт	77	3,906.5	71	1,677.6	86.8%
Нийт ИЗ, ТЗБАХ, ХО-н дүн		137	12,729.9	122	7,637.3	92.5%

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 136 ажилд өөрийн эх үүсвэрээс 11,175.5 сая төгрөгийг анх батлуулж, тодотголоор 12,729.9 сая төгрөгөөр 137 ажил төлөвлөснөөс, 7,637.3 сая төгрөгийг санхүүжүүлж, 92.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээг төрөл тус бүрээр үзэхэд:

- Их засварын ажлаас үндсэн тоноглолын их засварын 3 ажлаас 2 ажил 100%-ийн гүйцэтгэлтэй, 1 ажил 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Туслах тоноглолын 47 ажлаас 39 ажил 100%-тай хийгдэж дууссан, 5 ажил 55-95%-ийн гүйцэтгэлтэй, 3 ажлын худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна.
- Техник зохион байгуулалт, арга хэмжээний 10 ажил төлөвлөснөөс 10 ажил бүрэн хийгдсэн.
- Хөрөнгө оруулалтын 77 ширхэг тоног төхөөрөмжөөс худалдан авахаар төлөвлөснөөс 71 ширхэг тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдсэн. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 86.8% хувьтай.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болормаа, аудитор Ц.Одгэрэл, Ж.Наранчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь 2024 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн 01/157 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт цэвэр орлого 83,692.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 836.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглож, хязгаарласан зэрэг нийт 44 асуудлаар хянаж, тулгахад зөрчилтэй асуудал илэрсэн ба 25 нэр төрлийн зардлаас 9 нэр төрлийн зардлыг 7,331.7 сая төгрөгөөр хэмнэж, 16 нэр төрлийн зардал (түлш, цалин, НДШ, гал, борлуулалтын шимтгэл) 2,136.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд авсан судалгаагаар тус байгууллагад зөвлөх ажиллуулдаггүй, 14 тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах цэнхэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэсэн байна.

Тайлант онд цахим дэлгүүрээс 34.1 сая төгрөгийн 10 ширхэг машин тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Байгууллагын газартай холбоотой асуудлыг цэгцэлж, холбогдох гэрчилгээ, кадастрын зургийг баталгаажуулж, гэрээ байгуулж, 117.8 сая төгрөгийн 4 газрыг нэмж бүртгэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 170 талбарын мэдээллээс 2 мэдээллийн хугацааг хоцроож мэдээлсэн, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар мэдээллийг иж бүрэн үнэн зөв мэдээлж байх гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч тайлант онд "Тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлт оруулах хэсэгт" Эрчим хүчний сайдын 2024 оны А/164, А/293 дугаар тушаалаар 2024 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин тодотгосныг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн мэдээлсэн байдлын хэрэгжилт 99.3 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилт 99.3 хувьтай үнэлэгдсэн тул зөвлөмж хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцлийн асуудлыг үнэлэх асуудал үүсээгүй болно. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны 1-3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, аудитын явцад үйл ажиллагаатай танилцаж, бараа материал, үндсэн хөрөнгөөс түүвэрлэн, тооллого хийж, цалин тооцоолсон цагийн баланс, анхан шатны баримтуудыг тулган шалгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Азжаргал, Г.Даваасүрэн нар гүйцэтгэж, нийт 1,248.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 25.6 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 28.3 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1,194.7 сая төгрөгийн 7 зөвлөмж хүргүүлсэн байна.

Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн 01/728 дугаар албан тоотоор ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	5	25.6	5	25.6	100%
Албан шаардлага	1	28.3	1	28.3	100%
Зөвлөмж	7	1,194.7	7	1,194.7	100%
Нийт дүн	13	1,248.6	13	1,248.6	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад бүрэн хэрэгжсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч буюу Эрчим хүчний сайдад хамаарах асуудлын хүрээнд авч үзэхээр байна. Тухайлбал:

- Эрчим хүчний сайдын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/221 дүгээр тушаалын дагуу “Цахилгаан эрчим хүчний зөв зохистой хэрэглээ, үнэ тарифын шинэчлэлийн талаар сурталчлан таниулах контент” хийх ажлыг батлагдсан төсөвт өртгийг 5 хувааж 4 аж ахуй нэгжтэй 79.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

- Монгол Улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 01/345 дугаар “Хамтран ажиллах тухай”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар 08-ны өдрийн А-1/858 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх, Засгийн газрын бодлого, шийдвэрийг таниулан сурталчлах чиглэлээр ажлын хэсгийн томилолт унааны зардал 14,200,000 (арван дөрвөн сая хоёр зуун мянган) төгрөгийг байгууллагын төсвөөс санхүүжүүлсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланг э-тайлан болон татварын нэгдсэн системд шивэгдсэн санхүүгийн тайлан баталгаажсан тул залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 741.4 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 26.2 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 705.6 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 9.7 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Цалинтай чөлөө олгосон албан хаагчдад 1.9 сая төгрөгийн хоолны зардлыг олгосон, томилолтын хоолны зардлыг цалингийн хоолны зардалтай давхардуулан 0.9 сая төгрөгийг бодож олгосон, хамтын гэрээнд заасан хувь хэмжээнээс хэтрүүлэн 25 ажилтанд 6.9 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс бодсон, бүтээмж хэмнэлтийн урамшуулалд 5.2 сая төгрөг олгосон, “Эдийн засаг, санхүүгийн сургалт зөвлөгөө өгөх” ТББ-аас худалдан авах ажиллагааны сургалтыг давхардуулан 0.5 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан, “Олз мандал” ХХК-д эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй төрийн өмчийг түрээслүүлж, түрээсийн төлбөр 8.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, байгууллагын төсвөөр 2.7 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан зэрэг 7 зөрчилд 26.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Тайлант онд 3 ба түүнээс дээш жилийн насжилттай 23.7 сая төгрөгийн авлага нь 2018, 2020 онд шүүхийн шийдвэр гарсан байтал авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд орлогыг 33.6 сая төгрөгөөр илүү тайлагнасан, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн 38.2 сая төгрөгийн урамшууллыг сар бүр олгодог ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулсан, тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтаас зөрүүтэй илэрхийлсэн 595.9 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгэл тайланд тусгасан, шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх, Засгийн газрын бодлого, шийдвэрийг таниулан сурталчлах чиглэлээр ажлын хэсгийн томилолт унааны зардалд 14.2 сая төгрөгийг олгосон 5 зөрчилд 705.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 онд баталсан бөгөөд 2016-2024 онд шинэчлэгдсэн хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж : Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, батлуулах.

2. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Усны бохирдлын төлбөр 9.6 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүй нэмэгдсэн өртгийн албан татварын авлагаас бууруулж бүртгэсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/262 дугаар тушаалаар баталсан "Татварын орлого бүртгэх, орлогын данснаас татвар хооронд суутган тооцох журам"-ын 3.1-д "Татварын залруулга, зарлагын бүртгэлийг татвар төлөгчийн хүсэлт, татварын албаны шийдвэрээр хэрэгжүүлнэ", 5.4-т "Татвар төлөгч нь илүү төлсөн албан татварыг суутган тооцох хүсэлтийг харьяалах татварын албанд дор дурдсан хугацаанд хүргүүлнэ", 5.4.1-д татварын тайлангаар тодорхойлогдсон илүү төлөлтийг суутган тооцох хүсэлтийг тухайн төрлийн татварын хуульд заасан жилийн эцсийн тайлан хүргүүлснээс хойш дараа оны эхний тайлан хүргүүлэх хүртэлх хугацаанд" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд хуулийн дагуу өр төлбөрийг үнэн зөв тусгаж, тайлагнаж байх.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 1,631 нэр төрлийн 26,000.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үйл ажиллагаанд ашиглаж байгаа боловч үнийг шинэчлэн тогтоож дахин үнэлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ашиглагдаж буй элэгдлийн зардлаараа анхны өртгөө бүрэн нөхсөн 1,631 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлэх.

4. Дотоод аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд дотоод аудитор нь дотоод аудитын төлөвлөгөөний дагуу захирлын тушаал шийдвэрийн хэрэгжилт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны

хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлсэн байна. Хяналт шалгалтын үр дүнгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй, зөрчил дутагдал арилсан талаар нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын зааврын үлгэрчилсэн загвар"-ын "Компанийн засаглалын кодекс"-ийн хавсралт 73.4-т " ТУЗ нь дотоод аудитын үйл ажиллагааг дараах байдлаар хариуцаж ажиллана", 3.4.6-д "дотоод аудитын тайлан, дүгнэлттэй тухай бүр танилцаж, аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу авах арга хэмжээнүүдийн талаар шийдвэр гаргах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж :

Дотоод аудитын үр дүнгээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар арга хэмжээ авч ажиллах.

5. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд 170 мэдээлэл оруулахаас 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлт оруулах хэсэгт мэдээлэл огт оруулаагүй, эдийн засгийн зорилтот түвшинд 2 удаа тодотгол орсныг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.4-т "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж :

Шилэн дансны цахим системд байршуулах мэдээллийг иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрчлийн товч утга	1	1.9	1	1.9								
	1	0.9	1	0.9								
	1	6.9	1	6.9								
	1	5.2	1	5.2								
	1	0.5	1	0.5								

Олз мандал ХХК-д эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй төрийн өмчийг түрээслүүлж, түрээсийн төлбөр 8.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй.	1	8.1	1	8.1															
Байгууллагын төсвөөр 2.7 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан.	1	2.7	1	2.7															
Тайлант онд 3 ба түүнээс дээш жилийн насжилттай 23.7 сая төгрөгийн авлага нь 2018, 2020 онд шүүхийн шийдвэр гарсан байтал авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй.	1	23.7			1	23.7													
Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд орлогыг 33.6 сая төгрөгөөр илүү тайлагнасан.	1	33.6			1	33.6													
Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн 38.2 сая төгрөгийн урамшууллыг сар бүр олгодог ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулсан олгосон.	1	38.2			1	38.2													
Тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтаас зөрүүтэй илэрхийлсэн 595.8 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгэл тайланд тусгасан.	1	595.9			1	595.9													
Шинэ хоршоо хөдөлгөөнийг өрнүүлэх, Засгийн газрын бодлого, шийдвэрийг таниулан сурталчлах чиглэлээр ажлын хэсгийн томилолт унааны зардалд 14.2 сая төгрөгийг олгосон	1	14.2			1	14.2													
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 онд баталсан бөгөөд 2016-2024 онд шинэчлэгдсэн хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байна.	1	-								1	-								
Усны бохирдлын төлбөр 9.6 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүй нэмэгдсэн өртгийн албан татварын авлагаас бууруулж бүртгэсэн байна	1	9.6								1	9.6								



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 193/А 1470338
ОРА-2025/004/НА-СТА-ТВЧГ

Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олзмандал ХХК-д эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй төрийн өмчийг түрээслүүлж, түрээсийн төлбөр 8,096,000 (найман сая ерэн зургаан мянган) төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлд "Төрийн өөрийн өмч" 2-т "төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө", 26 дугаар зүйлд "Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах", "Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана", Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн өөрийн өмчийг түрээслүүлэх журам"-ын 1-т "Нийтлэг үндэслэл"-ийн 5-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэгч нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон төрийн өмчит хуулийн этгээд (цаашид "түрээслүүлэгч" гэнэ) байна. Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн эзэмшиж буй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг энэ журмын дагуу түрээслүүлнэ", 2-т "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах", 17-т "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.2-д "төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны

орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй” гэж заасныг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь түрээсийн төлбөр 8,096,000 (Найман сая ерэн зургаан мянга) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), ерөнхий нягтлан бодогч, санхүү, бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ

АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН

МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АХЛАХ

АУДИТОР:  Т.БОЛОРМАА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955





ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 194/А1470338
ОРА-2025/004/НА-СТА-ТӨҮТ

Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны хэлтсийн 2 мэргэжилтэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт худалдан авах ажиллагааны хуулийн тухай сургалтад хамрагдсан байтал "Эдийн засаг, санхүүгийн сургалт зөвлөгөө өгөх" ТББ-аас сургалтын төлбөрт давхардуулан 510,000 (таван зуун арван мянган) төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.6-д "сахилга баттай байх", 4.1.7-д "бодитой байх", 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК нь сургалтын зардалд олгосон 510,000 (Таван зуун арван мянга) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Эрдэнэтийн дулааны

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955

цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), ерөнхий
нягтлан бодогч, санхүү, бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг)
нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АХЛАХ
АУДИТОР:  Т.БОЛОРМАА





**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 213/A1470338
ОРА-2025/004/НА-СТА-ТӨЧГ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 3 ба түүнээс дээш жилийн насжилттай 23,657,240 (хорин гурван сая зургаан зуун тавин долоон мянга хоёр зуун дөчин) төгрөгийн авлага нь 2018, 2020 онд шүүхийн шийдвэр гарсан байтал авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Компанийн тухай хуулийн 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:", 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Насжилт ихтэй авлага 23,657,240 (хорин гурван сая зургаан зуун тавин долоон мянга хоёр зуун дөчин) төгрөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, биелэлтийг 2025 оны 07

дугаар сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮГЭХ
АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА
АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ
АХЛАХ АУДИТОР:  Т.БОЛОРМАА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 212/А1470338
ОРА - 2025/004/НА-СТА - ТӨҮГ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд орлогыг 33,548,806 (гучин гурван сая таван зуун дөчин найман мянга найман зуун зургаан) төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.1-д "борлуулалт" гэж барааг бусдын өмчлөлд шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхийг", 8.1-д "Албан татварыг доор дурдсан журмаар ногдуулна", 8.1.1-д "бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд орлогыг 33,548,806 (гучин гурван сая таван зуун дөчин найман мянга найман зуун зургаан) төгрөгөөр илүү тайлагнасан зөрчлийг дахин давтахгүй байж, биелэлтийг 2025 оны 07 дугаар

сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:  Т. ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б. БУЯН-УНДРАХ

АХЛАХ АУДИТОР:  Т. БОЛОРМАА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 211/А/1470338
ОРА-2025/004/НА-СТА-ТӨИГ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 38,321,500 (Гучин найман сая гурван зуун хорин нэгэн мянга таван зуун) төгрөгийн урамшууллыг сар бүр олгодог ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг зөрчсөн байна.

